



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 18 өдөр

Дугаар А/390

Номгон

Иргэн Б.Цэрэннадмидын эзэмшил газрын  
зөрчлийг арилгах тухай

Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2 дахь заалт, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн “Газрын харилцааны талаар авах арга хэмжээний тухай” 135 дугаар тогтоолын 1.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Иргэн Б.Цэрэннадмидын Баянхонгор сум, Рашаант 10 дугаар баг, Шинэ төгөл-1 гудамж, 1936 тоот хаягт байрлах ус түгээх цэгийн зориулалттай газрын илүү эзэмшиж буй 160 м2 газрын үнийг төлүүлэн нэмж эзэмшүүлж, хавсралтаар баталсугай.

2.Газрын талбайн хэмжээ өөрчлөгдсөнтэй холбогдуулан эзэмшил газрыг улсын бүртгэлд бүртгэн гэрчилгээ олгож, гэрээний биелэлтийг жил бүр дүгнэн ажиллахыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Д.Алтангэрэл), эзэмшил газарт Улсын бүртгэлийн “Э” дугаар олгохыг Улсын бүртгэлийн хэлтэс (Ц.Мөнхжаргал) нарт тус тус үүрэг болгосугай.

3.Эзэмшил газрыг зориулалтын дагуу зүй зохистой ашиглаж цаашид дээрх зөрчлийг гаргахгүй байхыг иргэн Б.Цэрэннадмидад үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Т.Хишигбаатар)-т даалгасугай.


ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

621010981

Аймгийн Засаг даргын 2021 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн А/396 дугаар захирамжийн



ЭЗЭМШИЛ ГАЗРЫН ТАЛБAYН ХЭМЖЭЭ ӨӨРЧЛӨГДӨЖ  
БАЙГАА ИРГЭНИЙ МЭДЭЭЛЭЛ

д/д	Газар эзэмшигчийн нэр	Регистрийн дугаар	Нэгж талбарын дугаар	Зориулалт	Хаяг	Талбайн хэмжээ /м2/	Залруулгаар нэмэгдэж байгаа талбайн хэмжээ /м2/	Нийт талбайн хэмжээ
1	Б.Цэрэннадмид	ВЮ88072628	64090081 37	Ус түгээх цэг	Баянхонгор сум, Рашаант 10-р баг, Шинэтөгөл-1 гудамж, 1396 тоот	45 м2	160 м2	205 м2

оОо